



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/237

Сүхбаатар сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.6 "л" заалт, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 239 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мандал сумын Түнхэл тосгонд зохион байгуулагдах "Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг"-ийн 2 дугаар шатны цогц үзлэг оношилгооны үйл ажиллагаанд ариутгал халдваргүйтгэлийн зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 2000000/хоёр сая/ төгрөгийн хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

3. Зардлын тайланг 2020 оны 09 дүгээр сарын 01-ны дотор гарган, аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ